



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/176

Сүхбаатар сум

### Аймгийн 2020 оны төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а" заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 70 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 299 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг 1 дүгээр, аймгийн төсвийн байгууллагуудын зарлага санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 2 дугаар, аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн сар, улирлын хуваарийг 3 дугаар, сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 4 дүгээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аймгийн төсвийн орлогыг батлагдсан хуваарийн дагуу бүрдүүлж ажиллахыг Татварын хэлтэс /Д.Цэрэнболд/-д, төсвийн ерөнхийлөн захирагчдын болон төсөвт байгууллагуудын зардал, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг холбогдох заавар журмыг үндэслэн хуваарийн дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

3.Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн сарын мэдээ, нэгдсэн тайланг хуульд заасан хугацаанд гаргаж тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430091350





